

**БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНД ДОТООД АУДИТ ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 11 дүгээр сарын 19

Багануур дүүрэг

1. Шалгалтын үндэслэл:

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Багануурын дулааны станц ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны журам” болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны даргын 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийх” тухай 25/03 дугаар удирдамжийн хүрээнд худалдан авах ажиллагаанд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

2. Шалгалтын зорилго:

Компанийн худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу явагдсан эсэх, үнэлгээний хорооны ажилласан байдал, ХАА-ны гүйцэтгэл, гэрээ биелэлт, гэрээ дүгнэж алдангийн тооцоолол хийж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгч шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгөхөд оршино.

3. Хяналт шалгалтын хамрах хүрээ, хугацаа:

Компанийн 2025 оны эхний 10 сарын байдлаар зохион байгуулсан худалдан авах ажиллагааг 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр компанийн Хангамжийн хэлтсээс худалдан авах ажиллагаатай холбоотой баримт материалыг хүлээн авч хяналт шалгалтын ажлыг эхлүүлж 11 дүгээр сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

4. Хяналт шалгалтад хамрагдах асуудлууд:

4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үнэлгээний хорооны ажилласан байдалд хяналт хийх

“Багануурын дулааны станц” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 01 сарын 10-ны өдрийн А/05 дугаар тушаалаар 2025 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг баталсан. Өөрийн хөрөнгийн 2,344,780,677.34 төгрөгөөр их засвараар хийгдэх 5 ажил, хөрөнгө оруулалтаар хийгдэх 15 ажил, техник зохион байгуулалтын арга хэмжээнд хийгдэх 2 ажил болон зардалд тооцсон худалдан авалтын нийт 25 ажлыг төлөвлөгөөнд тусгасан байна. Тендер шалгаруулалтын аргаар ангилбал:

- Нээлттэй тендер шалгаруулалт - 7
- Харьцуулалтын арга - 19
- Шууд худалдан авалт - 21 байна.

№	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр	Төрөл	Нийт төсөвт өртөг	Тендер шалгаруулалтын арга	Тендер шалгаруулалт зарлах сар	Тендер шалгаруулалт зарласан сар	Үр дүн гарч, гэрээ байгуулсан эсэх	Тайлбар
ТЗБАХэмжээнд хийгдэх ажил								
1	СН-5 насосны техникийн бүрэн шинэчлэл хэрэгжүүлэх	Бараа	80,000,000.00	ХА	2025 оны 2-р сар	2024.04.16	Үгүй	6 удаа зарласан
2	Үйлдвэрлэсэн болон түгээсэн ДЭХ-ний балансыг бодит байдалд хийж байх ажлыг эхлүүлэх /Салбаруудыг тоолууржуулах/	Бараа	30,000,000.00	ХА	2025 оны 2-р сар	2025.04.17	Тийм	
	Дүн		110,000,000.00					
Их засвараар хийгдэх ажил								
1	"КВТС-20-150" зуухны конвектив хэсгийн халах гадаргууг бүрэн солих, обмуровка шинээр солих	Ажил	198,776,603.00	НТШ	2025 оны 1-р сар	2025.04.21	Тийм	
2	Үйлдвэрийн байрны дээврийн хэсэгчилсэн их засвар гүйцэтгэх	Ажил	171,639,390.00	НТШ	2025 оны 1-р сар	2025.02.26	Тийм	
3	Станцын үйлдвэрлэлийн заалнуудын халаалтын регистр шинэчлэх	Ажил	34,978,298.00	ХА	2025 оны 2-р сар	2025.03.28	Тийм	8 удаа зарласан
4	ЦТП-8 -ийн бохирын худгийн системийг жижиг оврын "ЭКО" бохир цэвэрлэх станцаар шинэчлэх ажил гүйцэтгэх	Ажил	6,000,000.00	ШХА	2025 оны 5-р сар	2025.08.20	Тийм	
5	Төв объектын 3, 4-р давхруудын 00-ын өрөө, усанд орох өрөөнүүдийг засварлах	Ажил	38,300,000.00	ХА	2025 оны 2-р сар	2025.02.07	Тийм	4 удаа зарласан
	Дүн		449,694,291.00					
Хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил								
1	"КВТС-20" зуухны утаа сорогч /ДН-17/	Бараа	73,000,000.00	ХА	2025 оны 2-р сар	2025.03.15	Тийм	
2	Зуухны галын хотлын согло болон дагалдах материал	Бараа	84,960,000.00	ХА	2025 оны 1-р сар	2025.02.18	Тийм	3 удаа зарласан
3	Төрөл бүрийн хаалт	Бараа	12,150,000.00	ШХА	2025 оны 2-р сар	2025.01.28	Тийм	
4	Цахилгаан хөдөлгүүрүүд	Бараа	21,000,000.00	ХА	2025 оны 2-р сар	2025.02.04	Тийм	2 удаа зарласан
5	Оффисын тоног төхөөрөмж	Бараа	36,775,000.00	ХА	2025 оны 2-р сар	2025.01.17	Тийм	
6	ДХХА-ын тоног төхөөрөмж	Бараа	103,500,000.00	НТШ	2025 оны 1-р сар	2025.08.11	Тийм	
7	Туузан дамжууллын ремень-600	Бараа	20,000,000.00	ШХА	2025 оны 2-р сар	2025.08.05	Тийм	
8	Засварын сэлбэг материал	Бараа	66,440,000.00	ХА	2025 оны 2-р сар	2025.02.04	Тийм	
9	ГЗУ-н насос шинэчлэх /К-65-100-65-200/	Бараа	15,000,000.00	ШХА	2025 оны 2-р сар	2025.08.29	Тийм	
10	Универсаль трактор худалдан авах /1м3 шанагатай, 2.6м гүн ухах/	Бараа	205,000,000.00	НТШ	2025 оны 2-р сар	2025.09.12	Тийм	
11	"Ниссан кондор" ачааны автомашины мотор, моторын эзлж хийх ЛТ-100 бульдозер/	Бараа	28,000,000.00	ХА	2025 оны 2-р сар	2025.05.14	Тийм	6 удаа зарласан
12	К-3 зуухны ДС, ДВ дээр инвертор суурилуулах материал	Бараа	50,000,000.00	ХА	2025 оны 2-р сар	2025.03.31	Тийм	
13	Оффисын сандал ширээ	Бараа	24,150,000.00	ХА	2025 оны 2-р сар	2025.01.17	Тийм	

14	Төмрийн үртсэн деараторын шүүгч материал, хими хэсэгт давсны уусмалын бак	Бараа	14,500,000.00	ШХА	2025 оны 1-р сар	2025.01.29	Тийм	
15	Ф219*4мм-ийн шугамын дулаалга, изоляцийн материал (Цахимыг хос 100м шугам хэсэгчлэн дулаалах)	Бараа	10,500,000.00	ШХА	2025 оны 2-р сар	2025.08.05	Тийм	
	Дүн		764,975,000.00					
Зардалд тооцсон худалдан авалт								
1	Нүүрс тээврийн зардал	Ажил	212,560,342.05	НТШ	2025 оны 2-р сар	2025.06.23	Тийм	8 удаа зарласан
2	Харуул хамгаалалт	Ажил	33,214,578.00	ХА	2025 оны 2-р сар	2025.05.12	Үгүй	
3	Бичиг хэргийн материал	Бараа	14,402,721.27	ШХА	2025 оны 1-р сар	2025.12.31	Тийм	
4	Ажлын хувцас, гутал	Бараа	54,016,050.00	ХА	2025 оны 2-р сар	2025.02.18	Тийм	
5	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	Бараа	72,458,965.02	ХА	2025 оны 1-р сар	2025.03.27	Тийм	
6	Хувцас угаалга цэвэрлэгээний материал	Бараа	3,258,000.00	ШХА	2025 оны 1-р сар	2025.03.03	Тийм	
7	Инертийн материал	Бараа	6,300,000.00	ШХА	2025 оны 5-р сар	2025.04.01	Тийм	
8	Гамшгаас хамгаалах зардал	Бараа	11,555,500.00	ШХА	2025 оны 2-р сар	2025.08.29	Тийм	
9	Химийн бодис	Бараа	6,205,100.00	ШХА	2025 оны 1-р сар	2025.07.01	Тийм	
10	Давс	Бараа	41,800,000.00	ХА	2025 оны 3-р сар	2025.03.31	Тийм	
11	Шүүгч материал	Бараа	18,700,000.00	ШХА	2025 оны 2-р сар	2025.04.12	Тийм	
12	Багаж хэрэгсэл	Бараа	14,943,500.00	ШХА	2025 оны 2-р сар	2025.06.30	Тийм	
13	Шатах тослох материал	Бараа	185,075,880.00	НТШ	2025 оны 2-р сар	2025.04.30	Тийм	
14	Профан хий газ	Бараа	1,851,300.00	ШХА	2025 оны 1-р сар	-	Үгүй	
15	Кислород	Бараа	4,725,000.00	ШХА	2025 оны 1-р сар	-	Үгүй	
16	Өрлөг дулаалга	Бараа	153,899,850.00	НТШ	2025 оны 2-р сар	2025.03.18	Тийм	
17	Барилгын материал	Бараа	19,037,900.00	ШХА	2025 оны 2-р сар	2025.04.30	Тийм	
18	Цахилгааны материал	Бараа	40,359,700.00	ХА	2025 оны 2-р сар	2025.03.14	Тийм	5 удаа зарласан
19	Шуурхай ажиллагааны автомашины сэлбэг	Бараа	19,937,000.00	ШХА	2025 оны 2-р сар	2025.06.03	Тийм	
20	Бульдозерийн сэлбэг	Бараа	3,470,000.00	ШХА	2025 оны 2-р сар	2025.06.03	Тийм	
21	Мод, модны суулгац худалдан авах	Бараа	9,000,000.00	ШХА	2025 оны 9-р сар	2025.09.16	Тийм	
22	Аудитын үйлчилгээний хөлс	Үйлчилгээ	15,000,000.00	ШХА	2025 оны 3-р сар	2025.03	Тийм	
23	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон байгаль орчны нарийвчилсан үнэлгээ	Үйлчилгээ	18,040,000.00	ШХА	2025 оны 3-р сар	-	Үгүй	
24	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ	Үйлчилгээ	25,300,000.00	ХА	2025 оны 3-р сар	2025.09.11	Тийм	2 удаа зарласан
25	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Үйлчилгээ	35,000,000.00	ХА	2025 оны 3-р сар	2025.02.18	Тийм	
	Дүн		1,020,111,386.34					
	Нийт дүн		2,344,780,677.34					

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://www.tender.gov.mn/mn> - с авсан статистик мэдээлэл:

Төлөвлөсөн – 47

Зарласан – 26


Нээлт хийсэн – 26

Үр дүн гарсан – 26

Гэрээ байгуулах эрх олгосон – 24


Нийт зарласан тендерийн тоо, ширхэг

■ Үйлчилгээ
■ Бараа
■ Ажил



Нийт зарласан тендерийн төсөвт өртөг

■ Үйлчилгээ
■ Бараа
■ Ажил



Тендерийн баримт бичгүүдийг шалгаж үзэхэд:

- Төрийн худалдан авах цахим систем дээрх тендер шалгаруулалтын дугаар нь хэвлэж үдсэн баримт бичгийн дугаартай зөрж байгаа 4 тендер байна. /Цахилгаан хөдөлгүүрүүд, Оффисын сандал ширээ нийлүүлэх, Засварын сэлбэг материал, Оффисын тоног төхөөрөмж/
- БНДС/20250102016/01 дугаартай “Универсаль трактор худалдан авах /1м3 шанагатай, 2,6м гүн ухах” тендер шалгаруулалтын баримт бичгийн “ТШЗ 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр, 09 цаг 30 минут” гэж заасан

боловч тухайн тендерийн материалыг 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 09 цаг 30 минут хүртэл хүлээн авч 10 цаг 00 минутад нээсэн байна.

- БНДС/20250102036/02 дугаартай "Өрлөг дулаалга"-ын тендерт шалгарсан "Хүрэн хясаа" ХХК-д 2025 оны 05 сарын 22-нд "Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл" хүргүүлсэн ба тухайн мэдэгдэлд 2025 оны 06 сарын 01-ний өдрөөс хойш худалдан авах гэрээг баталгаажуулж ирүүлнэ гэсэн боловч 2025 оны 05 сарын 30-ны өдөр гэрээг байгуулсан байна.
- Нийт 26 тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулсан боловч 9 баримт бичгийг гүйцэтгэх захирлаар батлуулсан, 17 баримт бичгийг батлуулаагүй.

Үнэлгээний хорооны ажилласан байдал:

Компанийн хэмжээнд нийт АЗ гэрчилгээтэй 7 ажилтан байдаг.

№	Овог нэр	Албан тушаал	Гэрчилгээ авсан он сар өдөр	Гэрчилгээний дуусах хугацаа	Сертификатын дугаар
1	А.Баярмагнай	Хангамжийн хэлтсийн дарга	2023.01.27	-	2023/АЗ-0781
2	Г.Мөнгөншагай	Хангамжийн инженер	2023.01.27	-	2023/АЗ-0804
3	Л.Гантөгс	Үйлдвэрийн албаны дарга	2024.03.05	-	2024/0927
4	П.Батцэцэг	Горим тохируулгын инженер	2024.03.05	-	2024/0930
5	Э.Сэлэнгэ	Үйлдвэрийн үндсэн үзүүлэлтийн гэрээ, тооцооны инженер	2024.03.05	-	2024/0929
6	О.Алтмаа	Сүлжээний насосны ээлжийн машинч	2024.03.05	-	2024/0931
7	Л.Хишигжаргал	Эдийн засагч	2025.04.05	2028.04.15	2025/1790

2025 онд Үнэлгээний хороо байгуулсан нийт 26 тушаал гарсан. Нийт 10 хүн дараах байдлаар томилогдсон байна.

Үнэлгээний хорооны ахлагчаар: А.Баярмагнай – 11 удаа

Л.Гантөгс – 13 удаа

П.Батцэцэг – 2 удаа

Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар: А.Баярмагнай – 1 удаа

Г.Мөнгөншагай – 22 удаа

Э.Сэлэнгэ – 3 удаа

Үнэлгээний хорооны гишүүдээр: А.Баярмагнай -1 удаа

Г.Мөнгөншагай – 1 удаа

Л.Гантөгс – 2 удаа

П.Батцэцэг – 9 удаа

Э.Сэлэнгэ – 13 удаа

А.Эрчис – 15 удаа

Б.Мөнхчимэг – 11 удаа

Б.Одгэрэл – 3 удаа

М.Батчимэг – 12 удаа

Э.Алтангэрэл – 11 удаа тус тус томилогдон ажилласан байна.

Үнэлгээний хорооны гишүүдийн гарын үсэг дутуу 18 тендерийн баримт бичиг, үнэлгээний хорооны гишүүдийн хурлын тэмдэглэлийн он сар зөрүүтэй, алдаатай 15 баримт бичиг байна. Үнэлгээний хорооны гишүүд ирсэн тендерийн баримт бичгийг үнэлсэн байдлаар хянаж үзэхэд 1 тендер шаардлага хангаагүй байхад шалгаруулсан, 2 тендер шалгаруулалтын баримт бичгийг алдаатай боловсруулсан байна. Үүнд:

- БНДС/20250101003/01 дугаартай "КВТС-20-150 зуухны конвектив хэсгийн халах гадаргууг бүрэн солих, обмуровка шинээр солих" тендерийн төсөвт өртөг нь

198,776,603.00 төгрөг ба тендерийн баталгаа нь 0.5% буюу 993,883.06 төгрөг байх ёстой боловч тендер шалгаруулалтын баримт бичигт 858,196.9 төгрөг гэж заасан байна.

- БНДС/20250203045/01 дугаартай “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх” тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодохойлолтын 2.9-д “Эмнэлгийн байгууллага нь 5-аас доошгүй жил эмнэлгийн тусламж үйлчилгээг амбулатори болон хэвтэн эмчлэх хэлбэрээр үйлчилгээ үзүүлсэн байх” гэсэн шаардлагыг хангахгүй байна.
- БНДС/20250102012/01 дугаартай “ДХХА-ын тоног төхөөрөмж” тендерийн техникийн тодорхойлолтод галын хотлын датчик, сийрэгжилтийн дифференциаль датчик зэрэг бараанд марк заасан байна.
- Мөн БНДС/20250202012/01 дугаартай “Оффисын тоног төхөөрөмж” нийлүүлэх тендерт оролцогч компаниуд Сангийн яаманд 2 удаа гомдол гаргасан нь үндэслэлтэй тул тендерт шалгарсан компанийг буруу үнэлсэн байна гэж үзэж байна.

4.2. Гэрээ хэлцэл хуулийн дагуу зохион байгуулагдсан эсэх, ХАА-ны гүйцэтгэл, гэрээ биелэлт, гэрээ дүгнэж алдангийн тооцоолол хийж байгаа эсэхэд хяналт хийх

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://www.tender.gov.mn/mn> - ээр нийт 26 тендер зарласнаас 24 тендер амжилттай болж гэрээ байгуулсан буюу гүйцэтгэл 92.3%. Шууд худалдан авалтын 20 гэрээ байгуулсан ба гүйцэтгэл 95.2%-тай байна. Нийт худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 93.6%.

Төлөвлөгөөгөөр нийт 2,344,780,677.34 төгрөгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаас 2,116,968,502.87 төгрөгийн гэрээ байгуулж бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан ба 227,812,217.44 төгрөгийн хэмнэлттэй байна.

Нийт 44 гэрээ байгуулснаас 29 гэрээг дүгнэсэн ба 2,159,610.50 төгрөгийн алданги тооцсон байна.

№	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр	Төрөл	Нийт төсөвт өртөг	Гэрээний дүн	Хэмнэлт	Гэрээ байгуулсан сар, өдөр	Гэрээний дуусах хугацаа	Тооцсон алданги	Тайлбар
ТЗБАХэмжээнд хийгдэх ажил									
1	СН-5 насосны бүрэн шинэчлэл хэрэгжүүлэх	Бараа	80,000,000.00	-	80,000,000.00	-	-	-	Оролцогч байхгүй, Гэрээ байгуулаагүй
2	Үйлдвэрлэсэн болон түгээсэн ДЭХ-ний балансыг бодит байдалд хийж байх ажлыг эхлүүлэх /Салбаруудыг тоолууржуулах/	Бараа	30,000,000.00	29,600,000.00	400,000.00	2025.04.29	2025.05.29	-	Хугацаандаа нийлүүлсэн
Их засвараар хийгдэх ажил									
1	"КВТС-20-150" зуухны коневектив хэсгийн халах гадаргууг бүрэн солих, обмуровка шинээр солих	Ажил	198,776,603.00	193,938,345.87	4,838,257.13	2025.05.16	2025.09.01	-	2025.09.01-нд бүрэн угсарч дууссан, ажлын хэсэг 2025.10.24-нд ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэсэн.
2	Үйлдвэрийн байрны дээврийн хэсэгчилсэн их засвар гүйцэтгэх	Ажил	171,639,390.00	166,550,000.00	5,089,390.00	2025.04.07	2025.06.16	-	2025.10.08-нд дээврийн ажил гүйцэтгэсэн акт хүлээлгэн өгсөн, гэрээ дүгнээгүй байгаа.
3	Станцын үйлдвэрлэлийн заалнуудын халаалтын регистр шинэчлэх	Ажил	34,978,298.00	34,853,388.00	124,910.00	2025.09.17	2025.09.20	-	Ажил дуусаагүй, гэрээ дүгнээгүй байгаа.
4	ЦТП-8 -ийн бохирын худгийн системийг жижиг оврын "ЭКО" бохир цэвэрлэх станцаар шинэчлэх ажил гүйцэтгэх	Ажил	6,000,000.00	6,000,000.00	-	2025.08.20	2025.09.20	-	Хугацаандаа хийж гүйцэтгэсэн
5	Төв объектын 3, 4-р давхруудын 00-ын өрөө, усанд орох	Ажил	38,300,000.00	37,995,000.00	305,000.00	2025.06.18	2025.10.01	-	Хугацаандаа хийж гүйцэтгэсэн

	өрөөнүүдийг засварлах						Хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил					Гэрээ дүгнээгүй байгаа
							73,000,000.00	71,800,000.00	1,200,000.00	2025.04.02	2025.05.20	
1	"КВТС-20" зуухны утга сорогч /ДН-17/	Бараа										
2	Зуухны галын хотлын солло болон дагалдах материал	Бараа	84,960,000.00	83,000,000.00	1,960,000.00					2025.06.12	2025.08.12	Гэрээ дүгнээгүй байгаа
3	Төрөл бүрийн хаалт	Бараа	12,150,000.00	11,700,000.00	450,000.00					2025.01.28	2025.02.28	Хугацаандаа нийлүүлсэн
4	Цахилгаан хөдөлгүүрүүд	Бараа	21,000,000.00	20,490,000.00	510,000.00					2025.04.01	2025.06.01	2025.10.07-нд бараа нийлүүлсэн.
5	Оффисын төхөөрөмж	Бараа	36,775,000.00	32,131,000.00	4,644,000.00					2025.03.17	2025.04.17	Хугацаандаа нийлүүлсэн
6	ДХХА-ын төхөөрөмж	Бараа	103,500,000.00	100,000,000.00	3,500,000.00					2025.09.24	2025.10.24	Гэрээ дүгнээгүй байгаа
7	Туузан дамжууллын ремень-600	Бараа	20,000,000.00	20,000,000.00	-					2025.08.05	2025.09.20	2025.09.22-нд гэрээ дүгнэсэн. 2 хоногийн алданги болх 39,300 тегрөг тооцоогүй
8	Засварын сэлбэг материал	Бараа	66,440,000.00	63,729,000.00	2,711,000.00					2025.03.11	2025.05.12	Хугацаандаа нийлүүлсэн
9	ГЗУ-н насос шинэчлэх /К-65-100-65-200/	Бараа	15,000,000.00	15,000,000.00	-					2025.08.29	2025.10.13	Гэрээ дүгнээгүй байгаа
10	Универсаль трактор худалдан авах /1м3 шанагатай, 2.6м гүн ухах/	Бараа	205,000,000.00	183,800,000.00	21,200,000.00					2025.11.15	2026.01.15	Нийлүүлэх хугацаа болоогүй.
11	"Ниссан кондор" ачааны автомашины мотор, моторын ээлж хийх Л-100 бульдозер/	Бараа	28,000,000.00	27,980,000.00	20,000.00					2025.08.26	2025.09.06	Гэрээ дүгнээгүй байгаа
12	К-3 зуухны ДС, ДВ дээр инвертор суурилуулах материал	Бараа	50,000,000.00	48,800,000.00	1,200,000.00					2025.04.23	2025.06.09	2025.11.06 хүртэл сунгасан. Гэрээ дүгнээгүй байгаа.
13	Оффисын сандал ширээ	Бараа	24,150,000.00	22,682,000.00	1,468,000.00					2025.02.06	2025.03.06	Гэрээ дүгнээгүй байгаа
14	Төмрийн үртсэн деараторын шүүгч материал, хими	Бараа	14,500,000.00	13,805,000.00	695,000.00					2025.01.29	2025.04.30	Хугацаандаа нийлүүлсэн

	хэсэгт үүсмалын бак	давсны Ф219*4мм-ийн шугамын дулаалга, изоляцияйн материал (Цахимыг хос 100м шугам хэсэгчлэн дулаалах)	Бариа	10,500,000.00	-	2025.08.05	2025.09.20			Хугацаандаа нийлүүлсэн
15										
Зардалд тооцсон худалдан авалт										
1	Нүүрс зардал	Ажил	212,560,342.05	212,560,342.00	-	2025.07.23	2026.07	-		Хугацаа дуусаагүй.
2	Харуул хамгаалалт	Ажил	33,214,578.00	-	33,214,578.00	-	-	-		Оролцогч байхгүй, Гэрээ байгуулаагүй.
3	Бичиг хэргийн материал	Бариа	14,402,721.27	13,200,000.00	1,202,721.27	2025.01.13	2025.12.31	-		Хугацаа дуусаагүй байгаа.
4	Ажлын хувцас, гутал	Бариа	54,016,050.00	45,425,600.00	8,590,450.00	2025.03.20	2025.12.31	-		Хугацаандаа нийлүүлсэн.
5	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	Бариа	72,458,965.02	69,777,774.00	2,681,191.00	2025.04.29	2025.05.29	-		Гэрээ дүгнээгүй байгаа
6	Хувцас угаалга цэвэрлэгээний материал	Бариа	3,258,000.00	3,258,000.00	-	2025.03.03	2025.05.01	-		Хугацаандаа нийлүүлсэн.
7	Инертийн материал	Бариа	6,300,000.00	6,300,000.00	-	2025.04.01	2025.05.01	-		Хугацаандаа нийлүүлсэн
8	Гэмшгээс хамгаалах зардал	Бариа	11,555,500.00	11,555,500.00	-	2025.08.29	2025.10.13	22,700.00		2025.10.15-нд бараа нийлүүлсэн. 2 өдрийн алданги тооцсон
9	Химийн бодис	Бариа	6,205,100.00	6,205,100.00	-	2025.07.01	2025.09.01	-		Хугацаандаа нийлүүлсэн.
10	Давс	Бариа	41,800,000.00	40,920,000.00	880,000.00	2025.04.29	2025.12.31	-		Хугацаандаа нийлүүлсэн.
11	Шүүгч материал	Бариа	18,700,000.00	18,700,000.00	-	2025.04.02	2025.05.02	-		Хугацаандаа нийлүүлсэн
12	Багаж хэрэгсэл	Бариа	14,943,500.00	14,943,500.00	-	2025.06.30	2025.07.30	-		Хугацаандаа нийлүүлсэн
13	Шатах тослох материал	Бариа	185,075,880.00	161,329,998.00	23,745,882.00	2025.06.20	2026.07.01	-		Хугацаа дуусаагүй байгаа.
14	Профан хий газ	Бариа	1,851,300.00	1,851,300.00	-	2025.01.13	2025.12.31	-		Хугацаа дуусаагүй байгаа.
15	Кислород	Бариа	4,725,000.00	4,725,000.00	-	2025.01.13	2025.12.31	-		Хугацаа дуусаагүй байгаа.
16	Өрлөг дулаалга	Бариа	153,899,850.00	145,673,330.00	8,226,520.00					

17	Барилгын материал	Бараа	19,037,900.00	19,037,900.00	-	2025.04.30	2025.07.30	292,810.5	2025.09.12-нд сүүлийн барааг нийлүүлсэн. Хэсэгчилж алданги тооцсон.
18	Цахилгааны материал	Бараа	40,359,700.00	39,948,425.00	411,275.00	2025.08.26	2025.10.26	-	Гэрээ дүгнээгүй байгаа
19	Шуурхай ажиллагааны автомашины сэлбэг	Бараа	19,937,000.00	19,937,000.00	-	2025.06.03	2025.07.04		Хугацаандаа нийлүүлсэн
20	Бульдозерийн сэлбэг	Бараа	3,470,000.00	3,470,000.00	-	2025.06.03	2025.07.04	-	Хугацаандаа нийлүүлсэн
21	Мод, модны суулгац худалдан авах	Бараа	9,000,000.00	9,000,000.00	-	2025.09.16	2025.10.20	-	Хугацаандаа нийлүүлсэн
22	Аудитын үйлчилгээний хөлс	Үйлчилгээ	15,000,000.00	15,000,000.00	-	2025.03	2025.03	-	-
23	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон байгаль орчны нарийвчилсан үнэлгээ	Үйлчилгээ	18,040,000.00	-	18,040,000.00	-	-	-	Гэрээ байгуулаагүй.
24	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ	Үйлчилгээ	25,300,000.00	24,800,000.00	500,000.00	2025.10.20	2025.11.03	-	Хугацаандаа хийж гүйцэтгэсэн
25	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Үйлчилгээ	35,000,000.00	34,996,000.00	4,000.00	2025.03.17			Хугацаандаа хийж гүйцэтгэсэн
Нийт			2,344,780,677.34	2,116,968,502.87	227,812,217.44				

5. Илэрсэн зөрчил дутагдлын талаар:

“Багануурын дулааны станц” ТӨХК-ийн 2025 оны 1-10 сарын байдлаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Захиалагчийн тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдэлтийг шалгахад тендер шалгаруулалтын дугаар зөрүүтэй 4 тендерийн баримт бичиг, мөн 17 тендерийн баримт бичгийг гүйцэтгэх захирлаар батлуулаагүй, үнэлгээний хорооны гишүүдийн гарын үсэг дутуу, хурлын тэмдэглэлийн он сар зөрүүтэй зэрэг нь маш олон давтамжтай байна. Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 48 дугаар зүйлийн 48.4.-т заасан “Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд холбогдох баримт бичгийг хавсаргана” гэсэнтэй нийцэхгүй байна.
2. БНДС/20250101003/01 дугаартай “KBTC-20-150 зуухны конвектив хэсгийн халах гадаргууг бүрэн солих, обмуровка шинээр солих” тендерийн төсөвт өртөг нь 198,776,603.00 төгрөг ба тендерийн баталгаа нь 0.5% буюу 993,883.06 төгрөг байх ёстой боловч тендер шалгаруулалтын баримт бичигт 858,196.9 төгрөг гэж заасан байгаа нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн “14.2.Захиалагч тендерийн баталгааг төсөвт өртгийн 0.5 хувиар тогтооно” гэснийг зөрчсөн байна.
3. БНДС/20250102012/01 дугаартай “ДХХА-ын тоног төхөөрөмж” тендерийн техникийн тодорхойлолтод галын хотлын датчик, сийрэгжилтийн дифференциаль датчик зэрэг бараанд марк заасан байгаа нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 12 дугаар зүйлийн “12.4.Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тусгайлан заахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

6. Дүгнэлт, авсан арга хэмжээ

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах шийдвэр гаргуулна.

ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙСЭН:
ДОТООД АУДИТОР

ТАНИЛЦСАН:
БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.НАРАНТУЯА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

А.БАЯРМАГНАЙ

